

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**БУЛГАН АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ТӨВИЙН ЦЭВЭР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1.Булган аймгийн Гурванбулаг сумын төвийн ус түгээх байрны цэвэр усны үйлчилгээний тарифыг 3.63 төг/л-ээр (НӨАТ-гүй) баталсугай.
- 2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Булган аймгийн Гурванбулаг сумын Засаг дарга /Б.Дэлгэр/, "Булган мээж" ХХК /Б. Одхүү/-д тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Булган аймгийн Гурванбулаг сумыг ус хангамжийн үйлчилгээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг "Булган мээж" ХХК /Б. Одхүү/-д даалгасугай.
- 4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /С.Нямдаваа/-т даалгасугай.

ДАРГА Ж.БАТСУУРЬ

ГИШҮҮН

Л.БОЛД

Ж.ДАВААЦЭРЭН

Ч.ЭРДЭНЭЧИМЭГ